

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын  
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2021-02-25/**

Ажлын хэсгийн 53 дугаар хуралдаан 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 10.00 цагт цахим хэлбэрээр зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргалыг орлож Судалгаа, хөрөнгө оруулалтын газрын шинжээч Г.Мишээлт, Ашигт малтмал газрын тосны газрын хэлтсийн дарга М.Энхжаргал, мэргэжилтэн Р.Золзаяа, Нүүрс ассоциацийн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Эрдэнэцэцэг, Оюутолгой ХХК-ийн, ахлах менежер Т.Мөнхбат, Петрочайна Дачин тамсаг ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч Болормааг орлож Отгончимэг, Нээлттэй нийгэм форумын менежер Д.Эрдэнэчимэг, Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ын ТУЗ-ын гишүүн Д.Сүхбаатар, Ил тод сан ТББ-ийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, Хил хязгааргүй алхам ТББ-ийн тэргүүн Н.Баярсайхан, Захиргааны шинэ санаачилга ТББ-ийн тэргүүн Д.Цэрэнпүрэв, Транспаренси Интернэйшнл Монгол байгууллагын ерөнхийлөгч Л.Төр-Од, Их баяншарга ТББ-ын тэргүүн Л.Бор, МБОИЗ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд болон Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 14 гишүүн оролцож, ирц 42,4 хувьтай байв.

Мөн хуралдаанд Байгалийн баялагийн засаглалын хүрээлэнгийн зохицуулагч Н.Дорждарь, зөвлөх Н.Золжаргал, ТАН эвслийн гишүүн Бямбажав, Ууганцэцэг, Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ын Цэндсүрэн, Транспаренси интернэйшнл Монгол байгууллагын Билгүүн, Батбаяр, ОҮИТБС төслийн зохицуулагч З.Баярхүү, Мэдээлэл технологийн зөвлөх В.Нармандах, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг нар оролцов.

Хуралдааныг Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон удирдав.

Ш.Цолмон: Сайн байцгаанаа уу, ирцийн бүртгэл 19 хүн байсан, тэднийг хуралдаандаа холбогдон гэж найдаад хурлах эхлэх саналтай. Гишүүд зөвшөөрсөн тул Хөтөлбөрийн дагуу ББЗХ-ийн зохицуулагч Н.Дорждарийг урьж байна.

**Танилцуулга нэг: Авилигын эрсдэлийг тодорхойлох хэрэгсэл, ажлын дэд хэсэг байгуулах тухай.**

Н.Дорждарь: Өнгөрсөн хугацаанд 2021 оны ОҮИТБС-ын ажлын төлөвлөгөөг гаргасан байгаа. Уг төлөвлөгөөнд манай байгууллагын гаргасан судалгааны арга хэрэгслийг ашиглан олборлох салбарын авилгын судалгааг хийхээр болсон. Монгол улс энэ судалгааг хийж байгаа анхны улс болж байгааг тэмдэглэн хэлье. Энэ арга хэрэгсэл нь 6 үе шаттай. Хамгийн гол нь олон талын оролцоотой, хэд хэдэн системтэй асуумжид үндэслэлсэн судалгаа байгаа. Нэгдүгээрт, авилгын судалгааны дараа үнэлгээний тайлан гарна, үүн дээр үндэслэн цаашид юу хийх талаар төлөвлөгөө гарснаар энэ ажил дуусах юм. Энэ судалгаа нь ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч орнуудад цаашдаа хэрэгжүүлнэ гэж тооцож байгаа. Манай улсын хувьд олон талт ажлын хэсэгтэйгээ хамтарч хэрэгжүүлэх зорилготой байгаа. Энэ арга хэрэгслийг ашиглаад авилгад өртөгч байгууллагыг тогтооно, авилгыг өдөөгч сэдлийг тодорхойлно. Авилгад үндэслэлсэн мэдээлэл, прагматик гаргаснаар авилгыг тодорхойлно. Авилга нь хууль ёсны болон хууль бус гэж байдаг. Энэ арга хэрэгслийг ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч олон талт ажлын хэсэгт зориулсан байна. Энэхүү төсөл

ГХАН-ийн санхүүжилтээр хэрэгжинэ. Бид энэхүү аргачлалыг гаргахдаа ОҮИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарийн газар, томоохон компаниудын төлөөлөл болон бусад байгууллагуудтай хамтран ажилласан байгаа. Өнгөрсөн 2020 онд төслийн хүрээнд хийгдэх судалгааны арга хэрэгслийг боловсруулах ажлыг хийгээд түүнийгээ нягталж, хянаад хэдхэн хоногийн дараа дуусахаар байна. Бид энэхүү туршилт төслөө 6 сард дуусгаад цаашид олон улсад идэвхтэй танилцуулахаар төлөвлөж байгаа. Уг судалгаанд Ажлын хэсгээсээ дэд ажлын хэсэг гаргаад идэвхтэй хамтарч ажиллах мөн ажлын алба нилээд идэвхтэй зохицуулах, чиглүүлэх үүрэгтэйгээр оролцох болов уу. Энэ хурлаар ажлын дэд хэсэгт орох гишүүдийг сонгох саналтай байна. /Танилцуулгыг хавсаргав/

Ш.Цолмон: За баярлалаа, танилцуулгатай холбоотой санал, асуулт байвал хэлнэ үү.

Н.Баярсайхан: Энэ ажилд хариуцлагатай хандах хэрэгтэй гэж ойлгож байна. Ажлын алба нилээд идэвх санаачилгатай оролцсоноор энэ оны ажлын төлөвлөгөөний биелэлт болон стратеги төлөвлөгөөтэй хэрхэн уялдуулж илүү ач холбогдолтой болгох вэ гэдэг талаар ажиллах нь зүйтэй гэсэн саналыг хэлмээр байна. Дэд ажлын хэсэгт орох гишүүний нэрийг ТАН эвслээс ярилцаж байгаад өгнө, энэ ажлыг дэмжиж идэвхтэй оролцоно гэдгээ хэлье, баярлалаа.

Д.Сүхбаатар: Юуны өмнө Дорждарьд баярлалаа. Энэ ажил нь цаг үеэ олсон ажил байна, дэмжиж ажлын хэсэгт орж ажиллана гэсэн саналтай байна. Энэ ажлыг цаашаа өргөжүүлж ажиллах хэрэгтэй гэж үзэж байна. Төслийн эцсийн хувилбартай дэлгэрэнгүй танилцах боломж байгаа юу?

Н.Дорждарь: Энэ ажлын цар хүрээ ямар байхыг ажлын хэсэг тодорхойлох болж байна. Цаашдаа давтамжтай хийж болох байх. Бид аргачлалдаа олон саналуудыг тусгаад боловсруулж байгаа, дараа нь орчуулгын ажил хийгдэнэ, ерөнхийдөө 14 хоногийн дараа танилцуулах боломжтой. Үүний дараа шинжээчээ аваад ажлаа эхлүүлэх байдлаар тооцоолж байгаа.

Д.Цэрэнпүрэв: Энэ судалгаа нь ОҮИТБС-ын стандарттай хэр холбогдож байна вэ? Танай байгууллага энэ ажлыг яагаад хийж болохгүй байна вэ? Энэ хавар бид Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хуулийг УИХ-д өргөн барих гэж байна. Үүнтэй зэрэгцүүлэн авилгын талаар ярих нь хуульд батлуулахад нөлөөлөхгүй байгаа, гадна талын орчинтой уялдаж байж энэ ажлыг хийх байсан уу гэсэн асуулт, санал байна, баярлалаа

Н.Дорждарь: Стандарт ямар зүйлийг ил тод болгох вэ гэдгийг заасан байдаг. Энэ ажил маань стандартаар ил тод болсон мэдээллийг ашиглана, мөн үүнээс гадна холбогдох хүмүүстэй уулзах, ярилцлага авах зэргээр хийгдэнэ. Иймээс стандарттай нарийн уялдсан ажил болох байх. Цаашдаа ил тод болгосон мэдээллийг авилгаас урьдчилан сэргийлэхэд ашиглах ахиц дэвшил гарах болов уу гэж төсөөлж байгаа. Бид ажлын хэсэг, ажлын албатай нягт хамтраад арга зүйгээр хангахаас гадна бусад ажлыг эхнээс нь дуустал хийх болно. Манай байгууллага дангаараа хийж болох ч энэ ажил зөвхөн хөндлөнгийн үнэлгээ байдлаар хийгдэх болно. Харин Ажлын хэсэг, ажлын албатай хамтран ажилласнаар улс орны хэмжээний асуудлаас гадна дотооддоо болж байгаа асуудлыг гаргаж тодорхойлоо орох онцлог юм. Манай байгууллага олон улсын хэмжээнд байгалийн засаглалыг индексийн судалгааг хийдэг, одоо монгол улсын судалгаа хийгдэж байна. Авилгын судалгаа нь ил тод байдлын тухай хуулийг батлуулахад саад болохгүй байгаа гэж асууж байна би үүний

эсрэг бодолтой байна. ОҮИТБС нь өөрөө олон талт ажлын оролцоотой, санаачилгыг хэрэгжүүлэх өөрийн стандарттай байгууллага. Иймд авилгалыг ил болгох ажилд манлайлан оролцох боломжтой гэж харж байгаа. Авилгатай тэмцэх талаар санаачилга, ажил хийгдэж байгаа гэдгээрээ ил тод байдлын тухай хууль батлагдах магадлал нь илүү байж магадгүй гэсэн санаа төрж байна, Гэвч хүмүүс янз бурийн байдлаар тайлбарлах өөр өөрийн байрнаас тайлбарлахыг үгүйсгэхгүй. Харин санаачилгын давуу талуудыг ашиглан ажиллахад хуулинд садаа болохгүй болов уу гэж бодож байна.

Л.Төр-Од: Бид урьдчилан энэ төслийн танилцуулгыг ТАН эвслийн гишүүдэд танилцуулсан, манай гишүүд бүрэн дэмжиж байгаа. Энэ ажил нь ОҮИТБС-ын стандартын үзэл санаа, үзэл баримтлалтай нийцэж байгаа. ББЗХ-ээс Байгалийн засаглалыг тунхаг бичиг гэж гаргасан байна. Үүний 4.9-д аливаа улс орнуудын төр засаг нь байгалийн баялагийн орлогыг үр ашигтай нэмэгдүүлэх боломжийг ашиглах ёстой гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл авилгыг бууруулж алга болгосноор байгалийн баялагийн өгөөжийн эрх тэгш хүртэх боломж бүрдэнэ. Мөн манай ТАН эвслийн гол таван зарчимд нийцэж байгаа учраас бид дэмжиж байгаа. Ажлын хэсгийг гурван талын тэгш тэнцүү оролцоог хангаад явсан нь зүйтэй гэсэн саналтай байна. Энэ арга хэрэгслийг хэрэгжүүлэхтэй холбоотой ямар нэгэн ажлын болон санхүүгийн дэмжлэг хэрэгтэй байгаа юу?

Н.Дорждарь: Дэд ажлын хэсэг гурван талын тэнцүү оролцоотой байх саналыг дэмжиж байна. Төрийн байгууллагаас АТГ-аас нэг гишүүн оруулах санал байгаа. Бид 6 сар хүртэл ГХАН-ын санхүүжилтээр гарах зардуудыг санхүүжүүлнэ. Үүнд зөвлөх, сургалт семинар хэвлэлт, олон нийтэд хүргэх, хөндлөнгийн шинжээчийн зардал зэргийг санхүүжүүлэх боломжтой гэж тооцож байгаа. Цаашдаа хийгдэх ажлын төлөвлөгөө гарвал энэ талаар санхүүгийн эх үүсвэр боломжийг одоогоор төлөвлөөгүй байгаа энэ тухайн ажлын цар хүрээнээс шалтгаалах байх.

Ш.Цолмон: Бид УУХҮЯ-наас дэд хэсэг байгуулах тухай чиглэл авсан. Дэд хэсгийн даргаар ББЗХ-ийн зохицуулагч Дорждарь, нарийн бичгийн даргаар ажлын албаны зохицуулагч миний биеийг ажиллахыг зөвлөмж болгосон. Ажлын хэсэгт орох гишүүд нэрээ өгөхийг хүсье. АТГ-ын Цэнд-Аюушийг оруулах нь зүйтэй байх, өнөөдөр хурал давхацсан оролцоогүй байна. Ирэх 7 хоногт багтаагаад гишүүд саналаа ирүүлж болно.

Н.Эрдэнэцэцэг: Монгол нүүрс ассоциаци оролцох боломжтой.

Л.Төр-Од: Өнөөдөр үдээс хойш ТАН эвслийн зохицуулах зөвлөл хуралдаад гишүүдийн нэрсийг ажлын албанд хүргүүлнэ.

Т.Мөнхбат: Компаниуд хоорондоо ярилцаж байгаад төлөөллөө сонгох нь зөв байх, эргээд хариу өгье.

Б.Батболд: Нэг оролцогч талаас хэдэн хүн байхыг тодорхойлж өгсөн нь зөв байх.

Ш.Цолмон: Талуудаас гурав байхаар харагдаж байна. За баярлалаа.

Т.Мөнхбат: Тухайн төсөл, судалгаанд оролцох хүмүүст цалин урамшуулал байгаа юу?

**Н.Дорждарь:** Ажлын дэд хэсэгт ороогүй гишүүд ч нээлттэй оролцох боломжтой. Шинжээчийн хувьд төлбөр төлөх байх харин ажлын дэд хэсгийн гишүүдийн хувьд цалин, урамшуулалт өгөхийг татгалзаж байгаа.

**Танилцуулга хоёр: Монголын ОҮИТБС-ын дэд зөвлөлүүдийн 2021 оны ажлын төлөвлөгөө боловсруулах удирдамж, зөвлөмж**

**Н.Баярсайхан:** Бүгдэд нь сар шинийн мэнд хүргэе. Бид 2019,2020 оныг дэд зөвлөлийг чадавхижуулах жил болгож байсан боловч зарим шалтгааны улмаас дорвитой ажил хийгдэж чадаагүй учраас 2021 оны дахин дэд зөвлөлийн чадавхижуулах жил болгох санал тавьсан. 2020 оны 2 дугаар сарын 5-ны өдөр ОҮИТБС-ын дэд зөвлөлийн уулзалтын ажлын алба зохион байгуулсан. Үүнд 14 аймгийн дэд зөвлөлийн гишүүд оролцож, тайлангаа тавьсан. Хамтын ажиллагааны гэрээгээ дүгнэсэн 6 аймаг байсан үүнээс Ховд аймаг Нийтийн сонсгал хийж гэрээгээ дүгнэсэн зэрэг сайн талууд байсан. Одоо хийгдэж байгаа ажлуудаа танилцуулсан, харин олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг, мэдээлэл түгээх талаар ямар нэг ажил хийгээгүй байсан. Эдгээр 14 аймгууд тайлангаа танилцуулаад, тулгамдаж байгаа тодорхой саналуудыг гаргаж тавьсан. Тухайлбал, татвар гааль зэрэг босоо удирдлагатай байгууллагуудын оролцоо муу байдаг. Иймд эдгээр байгууллагуудыг төвийн удирдлагаас нь оролцуулж байх талаар Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлөөс үүрэг чиглэл өгөх зэрэг тодорхой саналуудыг оруулсан байна.

2021 оныг дэд зөвлөлийг хариуцлагажуулах жил болгосонтой холбогдуулан дэд зөвлөлүүдийг тогтмол цагт нэгэн зэрэг хийдэг ажилтай, иргэд нь оролцдог хүлээдэг арга хэмжээтэй болгох, туршлага хуримтлуулах, дэд зөвлөлүүд нь ОҮИТБС-ыг хангах чиглэлээр чанартай, хүртээмжтэй бүтээгдэхүүн гаргах, ОҮИТБС-ын Үндэсний зөвлөл, ажлын хэсгээс дэд зөвлөлийн ажлыг дүгнэх, нэгдсэн статистик мэдээлэл гаргахад хувь нэмэр оруулах, аймгууд ОҮИТБС-ын тайланд оролцох оролцоог сайжруулах зорилтуудыг тавьсан. Дэд зөвлөлийг байгуулахдаа гурван талын оролцоог тэгш хангах, 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж батлуулна. Аймгууд сумын дэд зөвлөлийг сургалтанд хамруулах, нэгтгэл тайлангаас өөрийн аймгийн мэдээллийг гаргаж, тайлангийн тойм гаргах, олон нийтэд танилцуулах сурталчлах, ИТХ болон ЗДТГ-ын өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлэх, 2022 оны төсвийн саналд дэд зөвлөлийн төсвийн санал оруулж батлуулах зэрэг ажлуудыг хийх нь зүйтэй. Мөн олон нийтэд чиглэсэн ажлыг зохион байгуулах, үүнд олон талт хэлэлцүүлэг хийх, тайлангийн мэдээллээр тойм бэлтгэн инфографик зэргээр олон нийтэд танилцуулах, мэдээллийн самбар, ТВ, мэдээллийг сувгуудаар ил тод болгох зэрэг олон нийтэд чиглэсэн ажлуудыг сошиал хэлбэрээр зохион байгуулах чиглэл өгье. ТАН эвслийн гишүүн байгууллагуудаас дэд зөвлөлд орж ажиллах нь зүйтэй байна. Дорнод, Ховд зэрэг аймгуудын дэд зөвлөлд ИНБ-ын төлөөлөл орсон нь илүү нөлөөтэй байна гэсэн дүгнэлт байна. За баярлалаа /танилцуулгыг хавсаргав/

**Ш.Цолмон:** Танилцуулгатай холбоотой асуулт, санал байвал хэлэхийг хүсье.

**Д.Цэрэнпүрэв:** ОҮИТБС-ын Дэд зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм байдал үүний 32.2 дугаар дэд зөвлөл нь ОҮИТБС-ын тайланг жил бүр нээлттэй хэлэлцүүлэх, түгээх гэж заасан байна. Үүнээс харахад дэд зөвлөлийн ажил үүргийн хуваарь нь байхад бид өөрсдөө хяналтаа тавиад, мониторинг хийгээд ажиллах нь чухал юм болов уу, хэтэрхий дэд зөвлөлийн ажлыг бид үүрээд байна. Дүрэм журамтайгаа танилцаад дүрмийн дагуу ажлаа хийж сурмаар байна гэсэн саналтай байна. Аймгуудын дэд зөвлөлд манай зарим гишүүд байдал билүү? Наранцэцэг Увс аймгийн дэд зөвлөлд, Баярсайхан Дорноговь аймгийн дэд зөвлөлийн гишүүнээр

ажилладаг гэж сонсож байсан. Өөрсдөө дэд зөвлөлд байдаг нь давуу талтай харагдаж байна. Миний бодлоор бид дэд зөвлөлийн ажлыг чиглүүлэх, хяналт мониторинг хийж ажиллах нь зүйтэй байх, түүнээс дэд зөвлөлийн ажил руу ороод сургалт хийгээд байх нь буруу болов уу. Бид ОУИТБС-ыг сурталчлах, хяналт мониторинг хийх үүрэгтэй байдаг. Бид хөдөө орон нутагт ажлаар явахдаа ажлын албанаас тараах материал, нэгтгэл тайланг авч явж тараадаг гэхдээ иргэдээс гадна сумын ИТХ, дэд зөвлөлд бас өгөх нь зүйтэй байна гэж хардаг. Өөрөөр хэлбэл дүрмийн дагуу ажиллах нь зөв байх, дэд зөвлөлийн хийх ажилруу орж ажиллах санал гараад байна уу гэж харж байна, баярлалаа

Л.Төр-Од: Бид ОУИТБС-ын хүрээнд энэ ажлыг хийх нь зүйтэй, зорилтын дагуу ажиллах нь зүйтэй. Стандартын 2.1 д Иргэний нийгмийн протоколд ИНБ-ууд нь ОУИТБС-ын үйл ажиллагааны төсөл, хэрэгжилт, хяналт, үнэлгээнд бүрэн дүүрэн идэвхтэй оролцох боломжийг хангана гэж заасан байдаг. Дэд зөвлөлийг чадавхжуулах ажил нь Ажлын хэсэг, ажлын албаны үндсэн үүрэг харин ТАН эвслээс дэд зөвлөлийг хариуцлагажуулах ажлыг хийх нь зүйтэй. Манай эвсэл Уул уурхайн хяналт гэсэн цахим платформтой болж байгаа. Энэ нь зөвхөн ТАН эвслийн нүүр царай болоод зогсохгүй, гэрээ болон ОУИТБС-ын цахим хуудастай уялдуулан орон нутагт аймаг руу чиглэсэн хяналт тавих механизмыг бүрдүүлнэ. Энэ цахим платформоо ирэх сарын эхний 7 хоногт багтаан олон нийтэд танилцуулна. 2018 онд ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газраас удирдамж гаргасан байдаг. Үүнд олон талт ажлын хэсгийг яаж байгуулах вэ гэдгийг тодорхой заасан байгаа. Олон улсын хэмжээнд Филиппин улсад мужуудад олон талт зөвлөл байдаг юм байна, мөн Казакстан улсад олон нийтийн зөвлөл ажилладаг эдгээр улсуудын туршлагаас суралцах, туршлага хуваалцах боломж байна гэж харж байгаа. Иймээс хариуцлага, хяналт талаас нь ТАН эвсэл илүү ажиллах зорилт тавьсан байгаа.

Н.Баярсайхан: Дэд зөвлөлийг байгуулах тогтоол нь 2012 онд гарсан, үүний дараа дэд зөвлөлийн дүрэм хэрэгтэй юм байна гээд миний бие бэлтгэн, Үндэсний зөвлөлд танилцуулж батлуулсан. Үүнд 5 чиглэлийн ажлыг зохион байгуулахаар оруулсан, өнөөг хүртэл Үндэсний зөвлөл, Ажлын хэсгээс дэд зөвлөлд ямар ч зөвлөмж чиглэл өгч байгаагүй. Орон нутагт бид очоод ОУИТБС-ын сурталчилгааг хийж байсан болохоос дэд зөвлөл хэрхэн ажиллах талаар санал зөвлөгөө өгч байгаагүй. Тийм учраас энэ ажлыг дэд зөвлөлийн ажил гэж харж болохгүй. Бид ямар нэгэн мөнгө төгрөггүй хийж байгаа, дэд зөвлөлд хэрхэн ажиллах талаар чиглэл зөвлөгөө өгч ажиллах нь зүйтэй. Бид Уул уурхайн яаманд ирээд ямар болсон билээ? Түүнээс гадна ирэх жил баталгаажуулалтад орно үүнд тайлан гаргахыг үнэлэхгүй ОУИТБС-ын үр нөлөөг үнэлнэ. Иймд бид дэд зөвлөлийг удирдамж, арга зүйгээр хангах хэрэгтэй. Өнөөдрийг хүртэл бид ямар ч аргачлал заавар өгч байгаагүй тиймээс энэ ажлыг хийх нь зөв гэж үзэж байна, дэд зөвлөлийг чадавхжуулах асуудлыг гурван жил хариуцлагатайгаар тавьж байсан. Бид аймаг сумдад очиж, хүн цуглуулаад үр дүнгүй гэдгээ харсан тэгэхээр одоо дэд зөвлөлийг ажиллуулах хэрэгтэй гэдгийг сайн ойлгох ёстой гэж хэлмээр байна.

Л.Төр-Од: Орон нутагт дэд зөвлөлийн байгуулахдаа талуудын тэгш оролцоог ханган гэдэгт заавал ТАН эвслийн гишүүн гэхгүй тухайн орон нутагт ажиллаж байгаа ИНБ, үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл зэргийг оролцуулах боломжтой гэж юм энэ талаар ОУ-ын байгууллагаас гаргасан 14 дүгээр Удирдамжид ч заасан байдаг.

Д.Цэрэнжав: Би харин зохицуулагчаас эсрэг санал хэлмээр байна. Ажлын хэсэгт манай ИНБ-ууд зонхилж оролцож, санал хэлж байна. Орон нутагт манай ИНБ-

үудын ажиллагаа, оролцоо бага байдаг. Дэд зөвлөлд ТАН эвслийн гишүүдийг оролцуулах нь маш чухал байна. 2021 онд дэд зөвлөлд орж ажиллах талаар ярилцаж, саналаа оруулсан. ОУИТБС-ын тайланг орон нутагт түгээх, гэрээг ил тод болгох ажлыг бид хийж болж байна. Орон нутгийн Дэд зөвлөлд ТАН эвслийг заавал оруулдаг жишиг тогтоох саналтай байна. Ажлын албаны зүгээс шаардлагатай бол холбогдох бичиг баримтад өөрчлөлт оруулах замаар дэд зөвлөлийн гишүүнд ТАН эвслийн төлөөллийг заавал оруулах талаар тусгаж, энэ ажлыг хэрэгжүүлэхэд тусалж, дэмжих хэрэгтэй гэсэн саналтай байна. Мөн харилцааны мэргэжилтний хийсэн Харилцааны стратеги, судалгаа хийх ажлын талаар бидэнтэй эхэлж зөвлөлдөх хэрэгтэй байсан, бид 10 гаруй жил энэ чиглэлээр ажилласан мэргэшсэн байгууллагууд юм. Манай Баярсайхан болон бусад гишүүд маш чухал санаануудыг гаргаж тавьсан, үүнийг хэрэгжүүлэхийн тулд уул уурхайтай орон нутаг, сумдын дэд зөвлөлд ТАН эвслийн гишүүдийг заавал оруулж ажиллуулах саналыг дэвшүүлж байна. ОУИТБС-ын дэд зөвлөл бол ямар ч хамаагүй ИНБ-ын байгууллага орж ажиллах зөвлөл биш юм. Манай ТАН эвсэл нь Олон улсын гишүүн байгууллага, ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч мэргэшсэн байгууллага учраас энэ зөвлөлд орж ажиллуулахад ажлын алба анхаар ажиллахыг хүсч байна, баярлалаа.

Л.Төр-Од: Миний санааг Цэрэнжав гишүүн хэлчихлээ. Бид дэд зөвлөлд доод тал нь 1-2 хүнийг оролцуулж ажиллуулахаар тохирсон байгаа. Үүний үр дүн хяналт мониторинг хийгдэх юм. Манай гишүүд ОУИТБС-ын талаар нилээдгүй чадавхижсан байгаа, манай гишүүн байгууллагууд сургалтанд хамрагдсан байна. Иймээс бид энэ туршлага, чадавхия хэрэгжүүлнэ.

3.Баярхүү: Бидний зүгээс 2 сарын 5-нд дэд зөвлөлтэй уулзалт хийсэн. Энэ уулзалтанд Баярсайхан гишүүн болон Дундговь аймгийн дэд зөвлөлийн гишүүн Отгонмөнхийг урьж оролцуулсан. Дэд зөвлөлийн уулзалт маш үр дүнтэй, амжилттай болсон. 2020 оны ажлын төлөвлөгөөнд Дэд зөвлөлийг чадавхижуулах талаар нилээдгүй ажил хийхээр төлөвлөсөн, Баярсайхан гишүүн бас чухал саналуудыг гаргасан байгаа үүний дагуу өнөөдрийн танилцуулгыг бэлтгэж танилцуулсандаа баяртай байна. Мөн дэд зөвлөлийн чадавхийг бэхжүүлэх талаар Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)-тай хамтран хэд хэдэн ажлыг хийхээр төлөвлөж байна. Тухайлбал, дэд зөвлөлийг чадавхжуулах сургалт хийх, орон нутагт мэдээллийг хэрхэн яаж түгээж олон нийтэд хүргэх талаар хийгдэх ажлуудыг ОУСК болон манай ажлын төлөвлөгөөнд оруулсан байгаа. Энэ ажлын хүрээнд 6 дугаар сард сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулна. Уг сургалтад Өмнөговь аймгийн дэд зөвлөлөөс 2 хүн, өөр бүсээс мөн 2 хүн болон ажлын хэсэг, ажлын албанаас оролцуулахаар тохирсон байгаа. Холбогдох зардлыг АХБ-ны төслөөс болон ОУСК хамтран санхүүжүүлнэ. Сургалтанд хамрагдсан сургагч багш сургалтын дараа 5 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч түүгээрээ орон нутагт очиж, сургалт хийх замаар ажиллах байгаа. Саяхан ОУСК болон ННФ хамтран Хакатон зохион байгуулсан, намар Дизайн хакатон зохион байгуулах илүү орон нутаг руу чиглэхээр ярилцсан байна. Мөн хэвлэмэл ном комик хэвлэж тараах зэрэг ажлуудыг ОУСК-тай хамтран хийхээр ярилцсан байна. Манай ИНБ-аас гаргасан саналыг дэмжиж байна, дэд зөвлөлд орж ажиллах санал гаргасаанд баяртай байна. Бид 2021 оны төлөвлөгөөнд олон ажлуудыг хийхээр төлөвлөсөн, ажлын алба хүн хүч багатай байдаг, ажлын хэсгээс хамтарч ажиллах талаар ажлын албанд ярилцаж байсан гэтэл та бүхэн өөрсдөө ажиллах санал гаргасанд талархаж байна. Өнөөдрийн хуралдаан үр дүнтэй болж байна, Баярсайхан гишүүний санаачилж хийж байгаа дэд зөвлөлийн удирдамж, зөвлөмж боловсруулж байгаад бид их талархаж байгаа. Аймгуудын дэд зөвлөлийн хурал дээр төлөвлөгөөгөө хэрхэн боловсруулах талаар мэдэхгүй, эргэлзсэн хүмүүс байсан, тодорхой зөвлөгөө арга зүй хэрэгтэй байгааг

харсан хараад өөрийн санаачилгаараа удирдамж бэлтгэсэн байгаа, мөн идэвхтэй ажиллаж байгаа ТАН эвслийн гишүүддээ дахин талархал илэрхийлье.

Д.Цэрэнжав: Дэд зөвлөлийн талаар судалгаа явуулах ажлын даалгаварт санал аваад байсан тэр юу болсон бэ?

З.Баярхүү: Бид ажлын даалгавраа яамруу өгчихсөн байгаа, яам саналаа өгөхөөр бэлэн болно. Үнэлгээний хороо байгуулагдан үнэлгээ хийнэ.

Д.Цэрэнжав: Энэ судалгааны ажил манай байгууллага оролцох боломж байгаа юу? Зарлагдсан байгаа юу?

З.Баярхүү: Ажлын даалгаварт ОУИТБС-ыг илүү мэддэг байх шаардлагыг оруулсан, та бүхэн оролцох бүрэн нээлттэй байгаа, тендер зарлагдана. Эхлэлийн семинар дээр гаргасан та бүхний санал дээр үндэслэн энэхүү судалгааг хийхээр төлөвлөгөөнд тусгасан байгаа. Та бүхэн оролцох бүрэн боломжтой.

Ш.Цолмон: Ерөнхийдөө ажлын даалгавар нь бэлтгэгдээд яаман дээр очсон байгаа, тэгээд үнэлгээний хороо байгуулагдаад, тендер зарлагдана. Манай ИНБ ийнхан оролцох байх гэж бодож байгаа.

Д.Эрдэнэчимэг: Дэд зөвлөлийн чадавхижуулах ажлын талаар ТАН эвслийн гишүүдээс гаргасан саналыг дэмжиж байна. Баярсайхан гишүүний гаргасан санал яаж ажил хэрэг болох гэдэг нь хурлын шийдвэрээр баталгаажих байх. Өөрөөр хэлбэл хурлын шийдвэрийн дагуу Дэд зөвлөлд чиглэсэн удирдамж бэлтгэн аймгуудад албан бичгээр хүргүүлэх байх. Мөн гишүүдийн гаргасан саналын дагуу 1/ орон нутаг, аймгуудын дэд зөвлөлд ТАН эвслийн гишүүнийг оролцуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг ТАН эвсэл хэрэгжүүлнэ гэсэн байдлаар удирдамж хүргүүлэх саналтай байна. 2/ Түүний хэрэгжилт 2 сар тутамд хийх дэд зөвлөлийн цахим уулзалтаар үнэлгэдээд явна гэж ойлголоо. 2021 оны ажлын төлөвлөгөөнд дэд зөвлөлийн чадавхийг сайжруулах нилээн олон багц ажлуудыг хийхээр тусгасан байна. Үүний санхүүжилт нь баталгаажсан тодорхой ажлуудаас ТАН эвсэл аваад зохион байгуулах боломжтой. 3/ Ялангуяа бүсүүдийн уулзалт, тодорхой хугацаанд давтамжтайгаар хийгдэх чадавхижуулах сургалт, семинаруудыг бид хариуцан авч хиймээр байна. 4/ Дэд зөвлөлийн дүрэмд орон нутагт байгуулсан гэрээнүүдийг ил тод болгох тухай тусгагдаагүй, тухай үед гэрээний сайт ажиллаж эхлээгүй байсан. Орон нутгийн гэрээний хэрэгжилтийг хянах хүн одоогоор УУХҮЯ-нд байхгүй, гэрээнүүдийг орон нутгаас татаж авна гэдэг маш их цаг хугацаа шаардсан, нүсэр ажил болдог. Орон нутгаас авсан гэрээг бид гэрээний сайтад оруулж байсан боловч сүүлийн үед өөр ажлууд гарч ирсэн учраас цалгардсан байгаа. 5/ Иймд компаниудтай байгуулсан гэрээг тухай орон нутгийн дэд зөвлөлд хариуцуулах, тэдний хийх ажилд тусгаж өгөх Баярсайхан гишүүний саналыг дэмжиж байсан. Гэрээг ил тод болгох нь зөвхөн нэг ТББ-ын ажил биш, үүнд ажлын алба санаачилгатай ажиллах хэрэгтэй байна. Энэ талаар албажуулах ажлыг олон удаа УУХҮЯ-д тавьж байсан боловч одоог хүртэл ахиц гарагхгүй байна. Иймд дараагийн 6/ ажлын хэсгийн хурлыг гэрээний ил тод байдлын талаар хэлэлцэх хурал болгох саналтай байна. Тухайн хурлаар гэрээг ил болгох ажил нь ямар ажлуудыг хийгээд одоо яагаад гацчихаад байна түүнийг урагшлуулахын тулд юу хийж шаардлагатай байгаа талаар хэлэлцэж, албажуулах саналтай байна. Манай ННФ-оос танилцуулга бэлтгэж, асуудлыг танилцуулах боломжтой, хурлаар УУХҮЯ-наас албажуулж, чиглэл гаргуулах саналтай байна, баярлалаа.

**3.Баярхүү: Дараагийн ажлын хэсгийн хурал дээр энэ асуудлыг танилцуулаад шийдвэр гаргуулья.**

**Д.Эрдэнэчимэг:** Дараагийн ажлын хэсгийн хурлыг яаралтай болж өгвөл 3 сардаа багтаагаад хиймээр байна. Гэрээний сайт байгуулснаас хойшхи ажиллагааг Ажлын алба хариуцна гэж Санамж бичигт заасан байдаг, сайтаа хүлээлгээд өгчихмөөр байна одоог хүртэл ННФ авч явж байна. Энэ ажил санаачилгын хүрээнд хийгдсэн төрийн ажил юмуу? нэг ТББ-ын ажил юмуу гэдгийн ялгаа заагийг гаргаж урагшуулмаар байгаа. Иймд ажлын хэсгийн хурал хэзээ болохыг хүлээлгүй, яаралтай зохион байгуулах саналтай байна.

**3.Баярхүү: Ажлын хэсгийн хуралд танилцуулахаас өмнө яам, ажлын алба, ажлын хэсгээс хамтарч яаж ажиллах талаар ярилцаад, шийдвэрийн төсөл бэлтгээд ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэх саналтай байна. Өөрөөр хэлбэл ойлголтоо нэгтгээд танилцуулсан нь зөв байх.**

**Д.Эрдэнэчимэг:** Өнөөдрийн хуралдаанаас дараагийн Ажлын хэсгийн хурлаар гэрээний ил тод байдлын талаар хэлэлцэнэ гэсэн ерөнхий шийдвэрийг гаргаад баталчихвал түүний бэлтгэл ажлыг, ажлын алба болон манай байгууллага хэн нь хийж болно.

**Л.Бор:** Орон нутгийн гэрээ, газар нутгийн гэрээнүүд төдийлөн ач холбогдолтой биш байдаг. Томоохон стратегийн гэрээнүүд, хөрөнгө оруулалтын гэрээнүүдийг нууц гээд ил тод болгохгүй байна, гэрээ бол олон төрөл байдаг. Хөрөнгө оруулалтын гэрээнд том, эрх мэдэлтэй хүмүүс гарын үсэг зурчихдаг, гэрээний бонус гэж авдаг гэдэг. Гэрээний бонус заавал авах ёстой байдаг уу, сайн мэдэхгүй. Иймд УУХҮЯ яам гэрээний асуудлаа хариуцвал цаашдаа томоохон гэрээнүүдээ ил болгох асуудлыг хийх хэрэгтэй байна, энэ нь зөвхөн ТББ-ын ажил биш шүү, баярлалаа.

**Д.Эрдэнэчимэг:** Бор эгчийн саналыг дэмжиж байна, бид томоохон гэрээнүүдийг ихэнхийг оруулсан. Харин уран ашиглахтай холбоотой гэрээнүүд нууцлалын зэрэгтэй гээд сайтад ороогүй байгаа энэ асуудлыг яах талаар дараагийн хурлаар ярилцах нь зүйтэй.

**Б.Батболд:** Гэрээний талаар асуудлаа тэмдэглэж аваад дараагийн хуралдаа оруулмаар байна. Юм юм шүүрч аваад байвал, хурлын цаг хэцүү болох нь. Мөн энэ жилийн үнэлгээний хороонд орохгүй, гэрчилгээний хугацаа дууссан сунгаагүй байгаа.

**Ш.Цолмон:** Шийдвэрийн төсөлд хуралдаанаар гарсан саналуудыг хавсаргах, өнөөдрийн гаргасан гэрээний асуудлыг эхлээд санал байдлаар оруулья.

**Д.Эрдэнэчимэг:** Дараагийн хурлын шийдвэрийг өнөөдөр шийдчихмээр байна, шийдвэрийг ажлын хэсэг гаргана.

**Ш.Цолмон:** Бид ажлын хэсгийн удирдлагаас асуух саналтай байна.

**Д.Эрдэнэчимэг:** Гишүүдийн олонхи нь байна, бид хэнээс ч асуухгүй шийдвэрээ гаргах дүрэмтэй.

Л.Төр-Од: Эрдэнэчимэгийн саналыг зөвхөн нэг гишүүний санал гэж битгий ойлгоорой, энэ бол ТАН эвслийн санал юм. Хурлын шийдвэрт ингэж оруулах, хэзээ хийх өдрөө тогтох саналтай байна.

Ш.Цолмон: За ойлголоо.

Н.Баярсайхан: Саналыг дэмжсэн гишүүддээ баярлалаа. Өнөөдрийн хуралдаанаар гарсан саналыг Дэд зөвлөлийн удирдамж, зөвлөмжид нэмж тусгаад дахин гишүүддэд илгээх саналтай байна. Хоёрдугаарт аж ахуйн нэгжүүд дэд зөвлөлийг ажиллуулахад хэрхэн оролцох талаар санал хэлсэнгүй. Нүүрс ассоциаци оролцоно гэсэн, бид боловсруулах баяжуулах үйлдвэрт орж байгаа. Баяжуулах үйлдвэрийн холбоо, УҮҮА зэрэг хувийн хэвшлийнхэн яаж оролцох вэ? Төрийн байгууллагууд, УУХҮЯ дэд зөвлөлийг чадавхижуулахад хэрхэн ажиллах талаар саналыг бичгээр авмаар байна. Дэд зөвлөлийн удирдамж, арга зүйн баримт бичигт дээрх байгууллагуудын оролцоо, саналыг нэмж тусгах нь зүйтэй гэсэн саналтай байна. Үүнийг хийх боломж байна уу, албан бичиг хүргүүлээд саналыг авах боломжтой юу?

Т.Мөнхбат: Баярсайхан гишүүний танилцуулсан дэд зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах удирдамжийг дэмжиж байна. Манай компанийн үйл ажиллагаа Өмнөговь аймагт явагддаг тул бид Даланзадгадад байдаг менежерийг дэд зөвлөлд оруулахаар шийдвэрлэсэн байгаа. Бусад компаниудыг харж байхад гол үйл ажиллагаа явагдаж байгаа орон нутагтаа төлөөллөө оролцуулдаг байна. ИНБ-үүд аймгуудад хүнээ хуваарилах шаардлагатай байх. Манайх Өмнөговь аймгийн дэд зөвлөлд төлөөллөө оруулсан бусад аймагт үйл ажиллагаа явуулдаггүй учраас манай байгууллагаас хүн орох шаардлагагүй. Хоорондоо ярилцаад өөр санал гарвал хүргүүльье.

Ш.Цолмон: За баярлалаа, шийдвэрийн төслийг дэлгэрэнгүй байдлаар бэлтгээд гишүүддэд явуулж саналыг нь авъя. Дараагийн хурал гуравдугаар сарын сүүлээр байх болов уу. Өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөж байна.

#### ШИЙДВЭРҮҮД:

Монголын ОҮИТБС-ын Ажлын хэсгийн 53 дугаар хуралдаанаас дараах шийдвэрүүдийг гаргахаар тогтов. Үүнд:

1. Авилгын эрсдэлийг тодорхойлох хэрэгслийн тухай танилцуулгыг дэмжиж, Ажлын дэд хэсгийг байгуулж, ахлагчаар Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгийн зохицуулагч Н.Дорждарь, гишүүдэд АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комисsar Б.Ганхуяг, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Д.Энхболд, “Нүүрс” ассоциацийн нарийн бичгийн дарга Б.Эрдэнэцэцэг, “Транспаренси Интернейшнл- Монгол” ТББ-ын тэргүүн Л. Төр-Од, “Ил тод байдал сан” ТББ-ын тэргүүн Д. Цэрэнжэв, “Тогтвортой хөгжлийн төлөөх Хариуцлагатай уул уурхайн санаачлага” ТББ-ын Удирдах зөвлөлийн дарга Д. Сүхбаатар, нарийн бичгийн даргаар ОҮИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нарыг томилох;
2. Монголын ОҮИТБС-ын дэд зөвлөлүүдийн 2021 оны Ажлын төлөвлөгөө боловсруулах удирдамж, зөвлөмжийг баталж, дэд зөвлөлүүдэд хүргүүлэх;

3. Монголын ОҮИТБС-ын дэд зөвлөлүүдийн 2021 оны Ажлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг ОҮИТБС-ын ажлын албанд (Ш.Цолмон) даалгав.
4. Ажлын хэсгийн дараагийн хуралдааныг 2021 оны 3-р сарын 22-26-ны долоо хоногт хуралдуулж, гэрээний ил тод байдлын цахим сайт, ил тод болгох ажиллагааг хэлэлцэхээр тогтов.

Хуралдаан 12.20 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн  
дарга бөгөөд ОҮИТБС-ын Үндэсний  
зөвлөлийн нарийн бичгийн дарга,  
Ажлын хэсгийн ахлагч

A handwritten signature in black ink, appearing to read "Г.Нандинжаргал".

Г.Нандинжаргал

Хуралдааныг даргалсан:

ОҮИТБС-ын Ажлын албаны зохицуулагч

A handwritten signature in blue ink, appearing to read "Ш. Цолмон".

Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ОҮИТБС-ын Ажлын албаны  
Санхүүгийн ажилтан

A handwritten signature in blue ink, appearing to read "А.Отгонтунгалаг".

А.Отгонтунгалаг